



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2026 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/67

Улаанбаатар хот

Г Хяналтын тоог шинэчлэн батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, 2025 оны Засгийн газрын 215 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.8. дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 103 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Багш, багш мэргэжлээр суралцах болон багш, ажилтны хүүхдийг тэтгүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам" -ын 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэг, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад сургалтын төлбөрийн хөнгөлөлт, тэтгэлэг, сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл олгох 2026 оны хяналтын тоог нэгдүгээр хавсралтаар, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах иргэдэд олгох тэтгэлэг, сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлийн 2026 оны хяналтын тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Батлагдсан хяналтын тоог баримтлан хөнгөлөлт, тэтгэлэг, зээл олгох, цаашид хяналтын тооны ашиглалтын талаарх мэдээллийг 2026 оны 11 дүгээр сард багтаан танилцуулах, шаардлагатай тохиолдолд ашиглагдаагүй хяналтын тоонд зохицуулалт хийх санал боловсруулж, танилцуулахыг Боловсролын зээлийн сан /М.Төртогтох/-д даалгасугай.

4.Энэхүү тушаалыг хэрэгжилтийг удирдан зохион байгууллалтаар хангаж, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Дээд, мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга (Н.Нарангэрэл), Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Алтансүх/, Санхүү хөрөнгө оруулалтын газар (С.Должинсүрэн)-т тус тус даалгасугай.

САЙД



П.НАРАНБАЯР

1426010334

Боловсролын сайдын  
2026 оны 02 дугаар сарын 02-ны  
өдрийн 1/67-тушаалын  
нэгдүгээр хавсралт

ДОТООДЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СУРАЛЦАГЧИД  
СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТ, ТЭТГЭЛЭГ, СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН  
ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ 2026 ОНЫ ХЯНАЛТЫН ТОО

№	Хөтөлбөр	Хамрах хүрээ	I-VI сар	IX-XII сар
<b>ЗГ-ын 2025 оны 215 дугаар тогтоол</b>				
1	Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэг	Тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр дэд бакалавр, бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцагч	1350	1350
2	Засгийн газар хоорондын гэрээгээр суралцагч	Засгийн газар хоорондын гэрээний дагуу гадаад улсаас Монгол Улсад суралцах суралцагч	402	402
3	Зорилтот бүлгийн суралцагч	8.2.Зорилтот бүлэгт дараах суралцагч /8.2.1.бүтэн өнчин суралцагч; 8.2.2.нэг гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй өрхийн хагас өнчин суралцагч; 8.2.4.эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй өрхийн нэг суралцагч; 8.2.5.хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагч; 8.2.6.цаатан, тува, урианхай үндэстний өрхийн нэг суралцагч; 8.2.7.нэг гэр бүлийн 3 болон түүнээс дээш хүүхэд дотоодын сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр зэрэг суралцаж байгаа бол нэг суралцагч./	2653	2653
4	Зарим эрэлттэй мэргэжлээр суралцагч	Нийгмийн салбарт хомсдолтой байгаа зарим мэргэжлийн чиглэлээр дотоодын болон гадаадын сургалтын байгууллагад дэд бакалавр, бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах суралцагчид тэтгэлэг олгоно	1600	1500
6	Сургалтын төлбөрийн хөнгөлөлтөөр суралцагч	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн сургалтын байгууллагад дэд бакалавр, бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцах суралцагч (50%)		500
7	Сургалтын зээлээр суралцагч	10.1.Дотоодын сургалтын байгууллагад бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр, дэд бакалавр хөтөлбөрөөр суралцах иргэнд сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл	2050	2050
Нийт /215/			8055	8455
<b>ЗГ-ын 2024 оны 103 дугаар тогтоол</b>				

1	Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам	1.1.Багш мэргэжлийн сонгон бүлгийн төгсөгч, багш бэлтгэх сургалтын хөтөлбөрөөр суралцагч, багш мэргэжлээр дадлагажигч, орон нутагт мэргэжлээрээ ажиллах багш болон (цаашид хамтад нь "багш, суралцагч" гэх)-д төрөөс дэмжлэг	1850	1850
2	Багш, багш мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам	Боловсролын ерөнхий хуулийн 13.3.6-д заасан багш, ажилтны нэг хүүхэд (15 жил тасралтгүй ажилласан тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцагч)	300	300
		Нийт /103/	2150	2150
		<b>Нийт /дотоод/</b>	<b>10205</b>	<b>10605</b>

Боловсролын сайдын  
2026 оны 02 дугаар сарын 08-ны  
өдрийн 1167 тушаалын  
хоёрдгаар хавсралт

ГАДААДЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАХ  
ИРГЭДЭД ОЛГОХ ТЭТГЭЛЭГ, СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН  
2026 ОНЫ ХЯНАЛТЫН ТОО

№	Хөтөлбөр	Хамрах хүрээ	Шинээр элсэн суралцуулах
1	Ерөнхийлөгчийн тэтгэлэг	2025 оны Засгийн газрын 215 тогтоолын Дөрөв.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг-4.16 Бэлтгэл хөтөлбөрийн суралцагчид сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох бөгөөд орон нутгаас ирсэн суралцагч бол дотуур байрны зардал нэмж олгож болно. Дотоод/Бэлтгэл хөтөлбөр/	320
		2025 оны ЗГ-ын 215 тогтоолын Дөрөв.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг-4.17 Тэтгэлгийн үндсэн хөтөлбөрийн суралцагчид сургалтын төлбөр, амьжиргааны зардал (дотуур байрны болон хүнсний зардал) олгоно.	322
2	Засгийн газрын тэтгэлэг	5.3.1 Магистрын зэргийн өмнөх бэлтгэл хөтөлбөр (хэлний бэлтгэл), магистр болон докторын хөтөлбөрөөр сургалтад суралцах төрийн албан хаагч	-
		5.3.2 Тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр суралцагч	-
		5.3.3 Засгийн газрын тэтгэлэг (техникийн боловсролоос) бакалавр	-
4	Засгийн газар хооронд	6.3 Монгол Улсаас гадаад улсад суралцагчтай, журмын 1.5-д зааснаар, эсхүл журмын 1.6-д заасны дагуу баталсан хэмжээгээр амьжиргааны зардлын тэтгэлэг олгоно.	70
5	Гадаад зээл	10.3.1 "2+2 хөтөлбөр"-ийн хүрээнд дотоодын сургалтын байгууллагад эхний 2 жил амжилттай суралцаж, гадаадын сургалтын байгууллагад бакалаврын хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцах эрх авсан суралцагч	2
		10.3.2 бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах эрх авсан суралцагч (ДШИС)	10
		10.3.3 гадаадын сургалтын байгууллагад магистр, докторт суралцагч	20
НИЙТ			744